

Энэхүү ТМТ нь 2015 оны 10 сарын 22-ны өдрийн Англи хувилбарын орчуулга болно.



ASIAN DEVELOPMENT BANK

Монгол Улс: Бүс нутгийн ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг шинэчлэн сайжруулах замаар худалдааг дэмжих төсөл

Төслийн нэр	Бүс нутгийн ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг шинэчлэн сайжруулах замаар худалдааг дэмжих төсөл	
Төслийн дугаар	46315-001	
Улс орон	Монгол Улс	
Төслийн статус	Санал	
Төслийн төрөл / Тусламжийн хэлбэр	Зээл	
Хөрөнгийн эх үүсвэр / Хэмжээ	Зээл: Бүс нутгийн ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг шинэчлэн сайжруулах замаар худалдааг дэмжих төсөл	
	Азийн хөгжлийн сан	15.0 сая ам.доллар
Стратегийн зорилт	Хүртээмжтэй эдийн засгийн өсөлт Бүс нутгийн интеграцчилал	
Хөдөлгөгч хүчин зүйл	Засаглал ба чадавхийн хөгжил Хувийн хэвшлийн хөгжил	
Салбар / Дэд салбар	Аж үйлдвэр ба худалдаа – Худалдаа ба үйлчилгээ	
Жендэрийн тэгш байдал ба оролцоо	Жендэрийн асуудал хамаарахгүй	
Агуулга	Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ)-ын ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах, арга хэрэгслийн (УМЭХА) хэлэлцээрт нийцүүлэн Монгол Улсын УМЭХА арга хэрэгслийг сайжруулахад нь тус төсөл дэмжлэг үзүүлнэ. УМЭХА -ын тогтолцоог сайжруулах нь тус улсын хөдөө аж ахуйн гаралтай болон хүнсний бүтээгдэхүүний худалдааг өргөжүүлэх, эдийн засгийг төрөлжүүлэхэд зайлшгүй шаардлагатай. Эдгээр асуудлуудыг тодорхой хэмжээгээр төслийн хүрээнд шийдвэрлэхийн тулд лаборатори, хяналт шалгалтын байгууламжуудыг шинэчлэх, хяналт шалгалтын удирдлагын тогтолцоог бэхжүүлэх, УМЭХА -ын хяналт, шалгалтыг олон улсын стандартад нийцүүлэх зэрэг ажлууд хийгдэнэ.	

Төслийн үндэслэл ба 2014 оны байдлаар хөдөө аж ахуйн салбар нь ДНБ-ийн 14 Улс орны/Бүсийн хувь, улсын хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн 28 хувийг стратегитай уялдсан бүрдүүлж, улмаар Монгол Улсын хөдөө орон нутгийн эдийн засгийн голлох салбар болохыг нотолсон. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд хүний хөдөлмөр ихээхэн шаардагддаг тул хөдөө орон нутагт ажлын байр бий болгох эх үүсвэр юм. Хөдөөгийн хүн амын 85 орчим хувь нь мал аж ахуйгаас ихээхэн хамаардаг ба улсын нийт хүн амын гуравны нэгийг бүрдүүлж буй малчин, айл өрхүүдийн хувьд мал сүрэг нь орлогын цорын ганц эх үүсвэр болдог. Түүнчлэн хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх нь хот суурин газар руу шилжин суурьших эрмэлзэлтэй ард иргэдийг хөдөө орон нутагт ажлуулах, ажлын байрыг нэмэгдүүлэх зэрэг ач холбогдолтой.

Монгол Улсад хөдөөгийн ард иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, ядуурал, орлогын тэгш бус байдлыг багасгахад хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх, шинэчлэх зайлшгүй ач холбогдолтой. Бүтээмж өндөртэй эдийн засгийн суурь салбарыг хөгжүүлэх нь эдийн засгийн өсөлтийг дэмжих хязгаарлагдмал эх үүсвэр, боломжуудыг төрөлжүүлэхэд түлхэц болно. Эдийн засгийг төрөлжүүлэх нь өнөөгийн Монголын хамгийн том дунд хугацааны сорилт ба хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг илүү тогтвортой, хүртээмжтэй болгоход голлох үүргийг гүйцэтгэнэ.

3 сая хүн амтай, 52 сая мал сүрэгтэй Монгол Улсын хувьд мал аж ахуйн салбар нь эдийн засгийн өсөлтийн хангах томоохон хөдөлгөгч хүчин юм. Баялаг ихтэй Монгол Улсын хувьд мах, сүүн бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ хурдацтай нэмэгдэж буй Зүүн Хойд болон Төв Азийн орнуудын зах зээлийг хангах газарзүйн таатай байршилтай. Гэвч нийт махны үйлдвэрлэлийн ердөө 1.5 хувь нь экспортлогддог. Хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүний экспортын эргэлтийг УМЭХА-ын шаардлагад нийцээгүй стандартууд хязгаарлаж байна. Тухайлбал, мал аж ахуйн салбар, халдварт өвчинд нэрвэгдэх нь түгээмэл, тиймээс хяналтын илүү сайн тогтолцооны тусламжтайгаар тархалтыг зогсоох, бууруулах боломжтой. Бруцеллёз, адууны халдварт цус багадаа өвчин гэх мэт малын гаралтай ба хүнсээр дамжих халдварын тархалт өндөр байдаг. Тиймээс малын гоц халдварт өвчний тархалтаас сэргийлэх үүднээс Монгол Улсын худалдааны түншүүд Монгол Улсаас малын гаралтай амьд амьтан, амьтны гаралтай бүтээгдэхүүний импортыг түр

хугацаанд хориглох тохиолдол түгээмэл хэвээр байна.

Иймд, гаалийн болон хилээр дамжих нэвтрэх нөхцлийг хөнгөвчлөхийн зэрэгцээ УМЭХА-ыг олон улсын стандартад нийцүүлэн сайжруулах нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, Монгол Улсад хүртээмжтэй өсөлтийг хангах, эдийн засгийг төрөлжүүлэхэд зайлшгүй ач холбогдолтой болно.

Үр нөлөө	КАРЕК-ийн корридор дагуух хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүний худалдаа нэмэгдэнэ (КАРЕК-ийн Тээвэр ба худалдааг хөнгөвчлөх 2020 стратеги) Эдийн засгийг төрөлжүүлэх замаар илүү хүртээмжтэй, тогтвортой өсөлтийг хангах (2012-2016 оны Засгийн газрын мөрийн хөтөлбөр)
Үр дагавар	Дэлхийн худалдааны байгууллагын шаардлагад нийцэн УМЭХА сайжирна
Үр дүн	Лаборатори, хилийн боомтын хяналт шалгалт, хорио цээрийн байгууламжууд шинэчлэгдэнэ УМЭХА -н Мэдээллийн удирдлагын систем бий болно Олон улсын стандартад нийцсэн УМЭХА-н хяналт, шалгалтын тогтолцоо бүрэлдэнэ

Газарзүйн байрлал

Хамгааллын арга хэмжээний ангилал

Байгаль орчин	В
Албадан нүүлгэн шилжүүлэлт	С
Уугуул иргэд	С

Байгаль орчин, нийгмийн асуудлын товчоон

Байгаль орчин	АХБ-ны 2009 оны Хамгааллын бодлогын мэдэгдэл, Засгийн газрын эрх зүйн зохицуулалтын шаардлагад нийцүүлэн, Байгаль орчны урьдчилсан үнэлгээ (БОУЭ) болон Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-г боловсруулсан.
Албадан нүүлгэн шилжүүлэлт	Газар эзэмших/шилжүүлэн авах шаардлага гарахгүй тул төслийг албадан нүүлгэн шилжүүлэлтийн С ангилалд багтаасан.
Уугуул иргэд	Төслийн хувьд үндэстэн угсаатны цөөнхөд шууд болон шууд бусаар нөлөөлөхгүй тул уугуул иргэдийн С ангилалд багтсан болно.

Оролцогч талуудын харилцаа, оролцоо ба зөвшилцөл

Төслийн төлөвлөлтийн үед	Төслийн баримт бичиг бэлтгэх, төлөвлөлтийн явцад яамд, ургамал малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдал хариуцсан агентлагууд, хувийн хэвшлийн компани, мэргэжлийн холбоод, мах үйлдвэрлэгчид болон хөгжлийн түншүүдтэй өргөн хүрээний хэлэлцүүлгийг хийж гүйцэтгэсэн.
Төслийн хэрэгжилтийн үед	Үйл ажиллагааны зохицуулалт, мэдээлэл солилцоо, зохицуулалтыг хангах үүднээс Ургамал малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдал хариуцсан агентлагууд, Хүнс, хөдөө аж ахуйн яам, Сангийн яам болон Гаалийн ерөнхий газрын удирдлагаас бүрдсэн төслийн удирдах хороо ажиллана.
АХБ-ын хариуцсан Ажилтан	Кристина Лозано
АХБ-ны хариуцсан Газар	Зүүн Азийн газар
АХБ-ны хариуцсан Хэлтэс	Төрийн удирдлага, санхүүгийн салбар ба бүс нутгийн хамтын ажиллагааны хэлтэс, Зүүн Азийн газар
Хэрэгжүүлэгч агентлаг	Шадар сайдын ажлын алба, Төрийн ордон, Улаанбаатар, Монгол Улс

Хуваарь

Үзэл баримтлал батлах	2015 оны 5 сарын 27
Урьдчилсан судалгаа	2015 оны 5 сарын 25-29
Менежментийн хяналтын уулзалт	2015 оны 9 сарын 08
Батлагдсан	2015 оны 11 сарын 12
Сүүлд хийсэн хяналт	-
ТМТ-г шинэчилсэн	2015 оны 9 сарын 09

Төслийн мэдээллийн тайлан (ТМТ)–д төсөл болон хөтөлбөрийн талаарх хураангуй мэдээлэл багтдаг: ТМТ-д төслийн хэзэрэгжилтийн явцын талаарх мэдээллийг агуулдаг ба анхны хувилбарт зарим мэдээллүүд ороогүй байх боловч гарсан өөрчлөлтүүдийг боломжтой үед нь нэмж оруулдаг. Мөн төслийн талаарх урьдчилсан буюу тойм мэдээллүүдийг агуулдаг.

АХБ нь Төслийн Мэдээллийн Тайлан (ТМТ)-г ашиглаж буй хэрэглэгчид гагцхүү мэдээлэл олгох үүднээс бэлтгэсэн ба ямарваа нотолгоо/баталгаа болохгүй. АХБ нь чанартай мэдээллээр хангахыг эрмэлзсэн ба аливаа мэдээллийг “-үүн шиг” гэж илэрхийлэгдсэн нь арилжааны шаардлагыг хангах, тодорхой зорилгоор ашиглахад нийцэх эсвэл бусдын эрхэд халдахгүй байх гэх мэт ямарваа нэгэн шууд болон шууд бус баталгааг өгөхгүй. Нэн ялангуяа, тайланд агуулагдсан мэдээллийг үнэн зөв, бүрэн мэдээллээр хангахуйц гэдгийг батлах зорилго агуулаагүй болно.